

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн тайлан

/2015оны жилийн эцсийн байдлаар/

2015 оны жилийн эцсийн байдлаар манай байгууллагад нийт 35 хүсэлт ирсэн байна. Хуулийн хугацаанд хариу өгсөн 34, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 1 байна.

2014 оны жилийн эцсээр өргөдөл гомдол шийдвэрлэлт 17 хоног 15 цаг 6 минут байсан бол 2015 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл гомдол шийдвэрлэлт 10 хоног 1 цаг 29 минут болж буурсан байна.

Өргөдөл гомдлын хандалтын байдал:

- 1800-1200 тусгай дугаарын утсанд 5
- Засгийн газрын 11-11 төвд 3
- Иргэд хүлээн авах төвөөр дамжин ирсэн 6
- Нутгийн захиргааны байгууллагуудаас 21 тус тус өргөдөл цахим системд бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлын шат дамжлагыг дурдахад:

1. Цахим системээр ирсэн өргөдлийг хэвлэн удирдлагад танилцуулна.
2. Удирдлагын цохолтын дагуу холбогдох хэлтсийн даргад цахимаар шилжүүлнэ.
3. Хэлтсийн дарга нар холбогдох мэргэжилтэндээ цохож шилжүүлнэ.
4. Мэргэжилтэн өргөдлийн хариуг удирдлагад танилцуулна.
5. Тухайн өргөдлийг эзэнд албан бичгээр эсвэл утсаар болон бусад байдлаар танилцуулна гэсэн 5 үе шаттайгаар явагдаж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр хийсэн ажил:

- Нийслэлийн Засаг даргын тамгын газраас өгсөн зөвлөмжийн дагуу өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн хугацааг 9 хоног дотор оруулахаар ажиллаж байна.
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийж байна.
- Өргөдөл гомдлын хяналтын цонхыг мэргэжилтэн бүрийн компьютерт суулгасан.

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Ц.БУЯНЖАРГАЛ